



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 8/490

Улаанбаатар хот


Г

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрлөөр ажиллах эрхийг хасах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Зөрчлийн хуулийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Нийслэлийн Баянгол дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 0146339 дугаар шийтгэлийн хуудас, 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 02-13/197 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний их эмч Батсуурийн Янжиндуламын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр ажиллах эрхийг 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 3 сарын хугацаагаар хассугай.
2. Б.Янжиндуламын эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр ажиллах эрхийг хассантай холбогдуулан дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай:
  - 2.1 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр ажиллах эрхийг 3 сараар хассан тухай мэдээллийг эрүүл мэндийн ажилтны нэгдсэн санд бүртгэж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудсанд байршуулан нийтэд мэдээлэх;
  - 2.2 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр ажиллах эрх үүстэл буюу 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтад бүртгэж, оруулахгүй байх;
  - 2.3 Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөөр ажиллах эрхийг хүчингүй болгосон талаар тус яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороо /Д.Цэрэндагва/, Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөл /С.Чимэдцэрэн/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /О.Төмөрбаатар/, Монголын хувийн хэвшилийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо /Ч.Доржгүнсмаа/, нийслэлийн Баянгол дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс /Б.Нарангэрэл/-т албан бичгээр тус тус мэдэгдэх.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.

САЙД



д.САРАНГЭРЭЛ

081906